



**“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ”ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 05 дугаар
сарын 01-ний өдөр

Дугаар ТУЗ2026-03/03

Улаанбаатар
хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх хэсэг, тус компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.7-р дах хэсэгт гишүүдийн дийлэнх олонхын саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн ээлжит хуралд оролцсон гишүүдийн дийлэнх олонхын саналаар Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Цагаачийн Баатарсайханыг сонгосныг баталсугай.

2.Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь компанийн эрх, ашгийг дээдлэх зарчмыг баримтлан компанийн дүрэм болон ТУЗ-ийн хурлаар баталсан дүрэм, журмийн дагуу бүрэн эрхээ хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Ц.БААТАРСАЙХАН



**“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ”ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 05 дугаар
сарын 01-ний өдөр

Дугаар ТУЗ2026-03/04

Улаанбаатар
хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодыг байгуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 81 дугаар зүйлийн 81.1 дэх хэсэг, тус компанийн дүрмийн дугаар зүйлийн 8.9.11-р зүйл, Компанийн засаглалын кодексыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1.Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд Дотоод аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороотой байхыг тогтоосугай.

2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан хороодын дарга, гишүүдийн бүрэлдэхүүнийг дараах байдлаар баталсугай.

2.1 Эрсдэл, аудитын хорооны даргаар: Ц.Оюунцэцэг

Гишүүдэд: Д.Хулан
Д.Уянга

2.2. Нэр дэвшүүлэх хорооны даргаар: Д.Байгальмаа

Гишүүдэд: Ц.Отгонбаяр
Ц.Отгонсүрэн

2.3 Цалин, урамшууллын хорооны даргаар: Д.Болормаа

Гишүүдэд: Ц.Оюунцэцэг
Ч.Мөнхтуяа

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь харьяалсан хороодын үйл ажиллагаанд зохих журмын дагуу оролцож компанийн эрх, ашгийг дээдлэх зарчмыг баримтлан аливаа сонирхлын зөрчлөөс ангид байж, компанийн нууцыг чанд хадгалж шударгаар ажиллахыг үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Ц.БААТАРСАЙХАН